



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах орон тооны бус албаны
бүрэлдэхүүн, болон журам батлах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, Монгол Улсын Шадар Сайдын 2018 оны 120 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 1.3, "Эрчим хүчний үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 9.9.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг 1 дүгээр хавсралтаар, Компанийн "Гамшгаас хамгаалах орон тооны бус албаны журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус томилсугай.
2. Гамшгаас хамгаалах орон тооны бус албаны мэргэжлийн анги бүрэлдэхүүнийг шууд удирдлагаар хангаж, сургаж бэлтгэх, багаж техник, тээврийн хэрэгслээр хангах, гамшиг, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхийг "Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб"-ын дарга (Б. Алтансүх)-д үүрэг болгосугай.
3. Компанийн үйл ажиллагааны зардлын 1 хувийг 2024 оны төсөвт тусгуулан, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б. Амараа)-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Солонго)-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БЯМБАСҮРЭН



ЭХҮТ ТӨХХК-ийн гүйцэтгэх захиралын
2023 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн
А/41 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН ТООНЫ БУС ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Албан тушаал		Овог, нэр
	Үндсэн	Томилгоожсон	
1	Ерөнхий инженер	Штабын дарга бөгөөд албаны орлогч дарга	Балжиннямын Алтансүх
2	Захиалагч, техник хяналтын хэлтсийн дарга	Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга, Хоол хүнсээр хангах хэсгийн ахлагч	Лувсаншаравын Батхүү
3	Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга	Байгууллагын тогтвортой байдал, төлөвлөлт, бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан	Төртогтохын Солонго
4	Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга	Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орлогч дарга, дотоод хяналтын хэсгийн ахлагч	Доржийн Пүрэвсүрэн
5	Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	Хангалт, нөөц хариуцсан ажилтан Санхүүгийн хэсгийн ахлагч	Батаагийн Амараа
6	Аж ахуйн албаны дарга	Гамшгийн үед техник хэрэгсэл, автомашины бэлэн байдал хариуцсан ажилтан, Механикжуулсан бүлгийн ахлагч	Тогтохын Ганбат
7	СЭХ-ийн нар, салхи хариуцсан хяналтын ахлах инженер	Гамшгийн үед ар тал, хүн ам, нүүлгэн шилжүүлэлт хариуцсан ажилтан	Ганболдын Самдан
8	ЗТХХ-ийн цахилгааны хяналтын ахлах инженер	Гамшгийн үед ар тал, хүн ам, нүүлгэн шилжүүлэлт хариуцсан ажилтан, Шуурхай зохицуулалтын бүлгийн ахлагч	Алтанцэцэгийн Ганбаатар
9	ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн	Гамшгаас хамгаалах асуудал болон удирдлагын байр хариуцсан ажилтан	Нямдаваагийн Оюундэлгэр
10	Мэдээллийн технологи, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн	Гамшгийн үед холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан, Мэдээлэл, холбооны хэсгийн ахлагч	Чин-чулууны Алд-Уул
11	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын инженер	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, сургалт хариуцсан ажилтан, ХАБЭА-н хэсгийн ахлагч	Шийтэвийн Ариунаа
12	Нэгдсэн лабораторийн ахлах инженер	Гамшгийн үед анхны тусламж хариуцсан ажилтан	Цэгмидийн Алтантуяа
13	Албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн мэргэжилтэн	Штабын архив, сурталчилгаа, мэдээлэл, бичиг хэрэг хариуцсан ажилтан	Ганчулууны Баасандаваа
15	Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч	Материал хангамжийн хэсгийн ахлагч	Дүгэржавын Дүүриймаа

ОРОН ТООНЫ БУС МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэрс	Харъяал агдах нэгж	Албан тушаал	Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн д гүйцэтгэх үүрэг
<u>Нэг. Гамшгаас хамгаалах техникийн бүлэг</u>				
1	Алтанцэцэгийн Ганбаатар	ЗТХХ	Цахилгааны хяналтын ахлах инженер	Бүлгийн дарга
2	Бат-Эрдэнийн Энхнасан	ЗТХХ	Цахилгааны хяналтын инженер	Гишүүн
3	Бат-Эрдэнийн Түвшинжаргал	СЭХХ	СЭХ-ний хяналтын инженер	Гишүүн
4	Чулуунбаатарын Оюунболд	ЗТХХ	Цахилгааны хяналтын инженер	Гишүүн
5	Оюунбилэгийн Энхбаатар	ЗТХХ	Дулааны хяналтын инженер	Гишүүн
6	Шавираачийн Алтанхуяг	ЗТХХ	Дулааны хяналтын инженер	Гишүүн
7	Ганбаатарын Насандавга	ЗТХХ	Цахилгааны хяналтын инженер	Гишүүн
8	Ажайн Жандос	ЗТМХ	Цахилгааны зураг төсөл, магадлал хариуцсан инженер	Гишүүн
9	Мягмарсүрэнгий н Мөнгөнбилэг	СЭХХ	СЭХ-ний хяналтын инженер	Гишүүн
10	Ням-Осорын Улсболд	СЭХХ	СЭХ-ний хяналтын инженер	Гишүүн
11	Отгонбаярын Сүхбаатар	НЛ	Гагнуур, үл эвдэх сорилын инженер	Гишүүн
12	Цогбадрахын Цэрэнбат	НЛ	Гагнуур, үл эвдэх сорилын инженер	Гишүүн
13	Наранбаатарын Галтболд	НЛ	Механик судлалын инженер	Гишүүн
14	Намхаймядагий н Батзориг	НЛ	Цахилгаан техник, өндөр хүчдэл туршилтын инженер	Гишүүн
15	Гантулгын Батцэцэг	ЗТХХ	Цахилгааны хяналтын инженер	Гишүүн
16	Энхтуяагийн Бурмаа	ЗТХХ	Реле хамгаалалт, автоматикийн хяналтын инженер	Гишүүн
17	Нямдаваагийн Болорцэцэг	ЗТМХ	Дулааны зураг төсөл, магадлал хариуцсан инженер	Гишүүн
18	Дашсамбын Сансармаа	ЗТХХ	Төсвийн хяналтын инженер	Гишүүн
19	Нанзадсүрэнгий нНямзаяа	НЛ	Тос, тосолгооны шинжилгээний инженер	Гишүүн

20	Баярсайханы Шинэцэцэг	НЛ	Хими, усны шинжилгээний инженер	Гишүүн
21	Энхтөрийн Номин	НЛ	Техникч	Гишүүн
22	Дагвын Энхболор	ЗТМХ	Цахилгааны зураг төсөл, магадлал хариуцсан инженер	Гишүүн
23	Цэвээндээ Жавхлан	Гэрээт	Барилгын хяналтын инженер	Бэлтгэл идэвхтэн
<u>Хоёр. Хэв журам сахиулах бүлэг</u>				
1	Доржийн Пүрэвсүрэн	СЭХХ	Дарга	Бүлгийн дарга
2	Нямдаваагийн Оюундэлгэр	ЗУХ	Ахлах мэргэжилтэн	Гишүүн
3	Дашийн Бассайхан	СҮТ	Дарга	Гишүүн
4	Таравын Нямдаш	НЛ	Эрхлэгч	Гишүүн
5	Батаагийн Амараа	СЭЗХ	Дарга	Гишүүн
6	Нүүрэйн Болд	ЗТМХ	Дарга	Гишүүн
7	Аудитор	ЗУХ	Аудитор	Гишүүн
8	Ариунбатын Бадрал	ТЗА	Дарга	Гишүүн
9	Эрдэнээгийн Энхтайван	ЗТМХ	Ахлах инженер	Гишүүн
10	Галсүрэнгийн Бат-Очир	ЗТХХ	Дулааны хяналтын ахлах инженер	Гишүүн
11	Сүхбатын Жигжиджав	СҮТ	Менежер	Гишүүн
12	Мягмаржавын Давааням	СЭХХ	Ахлах инженер	Гишүүн
<u>Гурав. Механикжуулсан бүлэг</u>				
1	Тогтохын Ганбат	ААА	Дарга	Бүлгийн дарга
2	Лувсанваанчиги йн Начин	ААА	Жолооч	Гишүүн
3	Осорын Очирхуяг	ААА	Жолооч	Гишүүн
4	Нацагдоржийн Амарбаатар	ААА	Жолооч	Гишүүн
5	Цэндсүрэнгийн Батбилэг	ААА	Жолооч	Гишүүн
6	Одгэрэлийн Дамдиндорлиг	ААА	Жолооч	Гишүүн
7	Буяндэлгэрийн Буянбадрах	ААА	Жолооч	Гишүүн
8	Дамдинсүрэнгий н Батбаяр	ААА	Жолооч	Гишүүн

<u>Дөрөв. Анхны тусламж, хангалтын бүлэг</u>				
1	Шийтэвийн Ариунаа	ЗТХХ	ХАБЭА-н хяналтын инженер	Бүлгийн дарга
2	Чин-Чулууны Алд-Уул	ЗУХ	Мэдээллийн технологи, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн	Холбоочин
3	Цэгмидийн Алтантуяа	НЛ	Ахлах инженер	Гишүүн
4	Ганбаярын Мишээл	СЭХХ	Хяналтын инженер	Гишүүн
5	Цэнд-Оюуны Оюунсүвд	СЭХХ	Хяналтын инженер	Гишүүн
6	Батбаярын Буянхишиг	ЗТХХ	Дулааны хяналтын инженер	Гишүүн
7	Очирхуягийн Батцэцэг	ЗТХХ	Цахилгааны хяналтын инженер	Гишүүн
8	Төгсийн Нарантуяа	ЗТХХ	Төсвийн хяналтын инженер	Гишүүн
9	Улаанбаатарын Үүрийнтуяа	ЗТМХ	Дулааны зураг төсөл, магадлал хариуцсан инженер	Гишүүн
10	Нацагийн Оюун-Эрдэнэ	ЗТМХ	Цахилгааны зураг төсөл, магадлал хариуцсан инженер	Гишүүн
11	Энхболдын Номин	ЗТМХ	Сэргээгдэх эрчим хүчний зураг төсөл, магадлал хариуцсан инженер	Гишүүн
12	Дүгэржавын Дүүриймаа	СЭЗХ	Ахлах нягтлан бодогч	Бүлгийн дарга
13	Батсуурийн Батзаяа	СЭЗХ	Эдийн засагч	Гишүүн
14	Дамбын Энхзаяа	ААА	Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Гишүүн
15	Нацагдоржийн Дариймаа	СЭЗХ	Тооцооны нягтлан бодогч	Гишүүн
<u>Зургаа. Аврах бүлэг</u>				
1	Ганболдын Самдан	СЭХХ	Ахлах инженер	Бүлгийн дарга
2	Батхүрэлийн Сайнбаяр	СҮТ	Инженер багш	Гишүүн
3	Баярын Мөнх-Өлзий	СҮТ	Инженер багш	Гишүүн
4	Баярсайханы Олонбаяр	СҮТ	Инженер багш	Гишүүн
5	Алтангадасын Сүхбат	СҮТ	Инженер багш	Гишүүн
6	Мижиддоржийн Энхбаяр	СҮТ	Инженер багш	Гишүүн

7	Баярсайханы Хонгорзул	СҮТ	Инженер багш	Гишүүн
8	Баатартөрийн Нямгэрэл	СҮТ	Инженер багш	Гишүүн
9	Ганбатын Оролзодмаа	ТЗА	Мэргэжилтэн	Гишүүн
10	Володягийн Энхжаргал	СҮТ	Үйлчлэгч	Гишүүн
11	Мөнхбаярын Батчимэг	СҮТ	Үйлчлэгч	Гишүүн
12	Шаравын Ганболд	ААА	Сантехникч, аж ахуйн ажилтан	Гишүүн
13	Даваагийн Оюун-Эрдэнэ	ААА	Үйлчлэгч	Гишүүн
14	Баясгалангийн Энхжаргал	ААА	Үйлчлэгч	Гишүүн
15	Дорждагва Бямбажаргал	ЗУХ	Гэрээ хариуцсан мэргэжилтэн	Гишүүн
16	Эрдэнэбилэгийн Дөлгөөн	ЗУХ	Гадаад хамтын ажиллагааны мэргэжилтэн	Гишүүн
17	Захирлын туслах	ЗУХ	Захирлын туслах	Гишүүн
18	Мандалбаярын Болормаа	ЗУХ	Архив, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	Гишүүн
19	Ширэндэвийн Оюунгэрэл	ЗУХ	Хууль, эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Гишүүн
20	Нямдоржийн Золжаргал	Гэрээт	Захиалгын мэргэжилтэн	Бэлтгэл идэвхтэн
21	Сүхбаатарын Уянга	Гэрээт	Эх бэлтгэгч	Бэлтгэл идэвхтэн
22	Батчулууны Өсөхжаргал	Гэрээт	Хэвлэгч	Бэлтгэл идэвхтэн
23	Баттулгын Батчимэг	СҮТ	Инженер багш	Гишүүн

ЭХҮТ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын
2023 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн
А/41 дугаар хоёрдугаар тушаалын хавсралт

КОМПАНИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН ТООНЫ
БУС АЛБАНЫ ЖУРАМ



Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Монгол Улсын Гамшгаас Хамгаалах хуулийн дагуу Гамшгаас хамгаалах алба нь орон тооны бус бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулна.
- 1.2 Гамшгаас хамгаалах орон тооны бус алба нь болзошгүй аваар саатал, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, нийтийг хамарсан үймээн самуун, байгалийн гамшиг бусад шалтгаанаар улс, бүс нутгийн хэмжээнд онц байдал зарлах зэргээр онцгой нөхцөл байдал үүссэн үед байгууллагын хэвийн найдвартай ажиллагааг хангах, гарсан хор уршгийг арилгах, дахин гаргуулахгүй байх үйл ажиллагааг бүхэлд нь удирдан чиглүүлнэ.
- 1.3 Гамшгаас хамгаалах орон тооны бус алба нь компанийн үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээн дээр тулгуурласан гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, дүүргийн онцгой байдлын хэлтэст хянуулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.4 Жил бүрийн 1 дүгээр улиралд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэн хянаж, зохих өөрчлөлтийг хийж ажиллана.
- 1.5 Гамшгаас хамгаалах орон тооны бус алба нь энэхүү журмын хавсралтад заасан үйл ажиллагааны бүтцийн схемээр ажиллана.

Хоёр. Албаны удирдлага, бүтэц, зохион байгуулалт

- 2.1 ЭХҮТ ТӨХХК нь орон тооны бус гамшгаас хамгаалах алба байгуулна. ЭХҮТ ТӨХХК-ийн гамшгаас хамгаалах орон тооны бус албаны бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.
- 2.2 Гамшгаас хамгаалах орон тооны бус албаны даргаар гүйцэтгэх захирал, албаны орлогч даргаар ерөнхий инженер ажиллана.
- 2.3 Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, гишүүдийг томилно. Штабын даргаар ерөнхий инженер ажиллана.
- 2.4 Гамшгаас хамгаалах алба нь үйл ажиллагааны чиглэлээр гамшгаас хамгаалах техникийн бүлэг; хэв журам сахиулах бүлэг; механикжуулсан бүлэг; анхны тусламжийн нөхөрлөл, хангалтын бүлэг; аврах бүлгийн ахлагч, гишүүдээс бүрдэнэ.
- 2.5 Яам, тамгын газар, удирдах дээд байгууллагаас зохион байгуулах дайчилгаанд оролцох хүмүүсийн ажилд хяналт тавих, дүгнэлт гаргах, хөдөлмөрийн аюулгүй орчинг бүрдүүлэх, хоол хүнс, тээвэр, дулаан хувцсаар хангах, санхүү хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх албаны нэгжийг "Хэсэг" гэнэ. Материал хангамж; Хоол, хүнс; Санхүү; Дотоод хяналт; Мэдээлэл холбоо; Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэсгийн ахлагч, Механикжуулсан бүлэг; Шуурхай зохицуулалтын бүлгийн ахлагч нарыг томилно.
- 2.6 Бүлэг, хэсэг бүр нь өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гамшгаас хамгаалах албаны даргын шууд удирдлагад ажиллана.

Гурав. Гамшгаас хамгаалах алба түүний эрх, үүрэг

3.1. Гамшгаас хамгаалах албаны эрх, үүрэг

- 3.1.1 Гамшгаас хамгаалах орон тооны бус алба нь "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө"-ний дагуу компанийн найдвартай ажиллагааг хангах, болзошгүй аваар саатал, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлэх гарсан гамшгийн хор хөнөөлийг арилгах, дээд шатны гамшгаас хамгаалах алба, штабын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, онцгой байдал, цагдаа, хүчний байгууллагын мэргэжлийн анги, бүлгээс тусламж авах, цагийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл солилцох үндсэн үүрэгтэй.
- 3.1.2 Алба нь өөрийн нэгж дэх техникийн бүлэг, хэсгүүдэд шаардлагатай төхөөрөмж, автомашин, тээврийн хэрэгсэл, хүн хүч, боловсон хүчнийг бүрдүүлж байнгын бэлэн байдлыг хангаж ажиллана.
- 3.1.3 Монгол улсын гамшгаас хамгаалах тухай хууль, компанийн "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө"-ний дагуу болзошгүй аваар саатал, онцгой нөхцөл байдал үүссэн үед бэлэн байдлын зэрэгт шилжүүлж компанийн бүх шатны албан хаагч, ажилтанг дуудаж ажиллуулах эрхтэй.
- 3.1.4 Техникийн бүлгийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах, сургалтын гарын авлага, шаардлагатай материалаар хангах үүрэгтэй.

3.2 Албаны дотоод ажлын зохион байгуулалт

- 3.2.1 Гамшгаас хамгаалах орон тооны бус алба нь байгууллагын найдвартай ажиллагааг хангах болон онцгой байдал үүссэн цаг үеийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Гамшгийн хор хөнөөлийг арилгах, бэлэн байдал зарласан үед ээлжит бус техникийн шуурхай зөвлөгөөн, хурлыг зарлан хуралдуулна.
- 3.2.2 Шуурхай зөвлөлийн хурал, ээлжит бус зөвлөгөөнийг гамшгаас хамгаалах албаны дарга удирдан явуулна.
- 3.2.3 Техникийн бүлэг, хэсгийн ахлагч нар өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдсэн болон хийгдэх ажлууд, цаг үеийн асуудлуудын талаар мэдээлэл, өөрсдийн санал, дүгнэлтийг танилцуулна.
- 3.2.4 Гамшгаас хамгаалах орон тооны бус албаны дарга нь бүлэг, хэсгийн ахлагч нарын мэдээлэл, санал, дүгнэлтийг үндэслэн цагийн байдалд үнэлэлт өгч, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүрэг даалгавар, шийдвэрийг гамшгаас хамгаалах штабын дарга, бүлэг, хэсгийн ахлагч нарт өгнө.
- 3.2.5 Гамшгаас хамгаалах орон тооны бус албаны даргын шийдвэр, үүрэг даалгаврыг бүлэг хэсгийн ахлагч нар хурдан шуурхай, чанартай биелүүлэх үүрэгтэй бөгөөд биелэлтэд дотоод хяналтын хэсгийн ахлагч хяналт тавина.

- 3.2.6 Гарсан гамшгийн хор хөнөөлийг арилгахад өөрсдийн хүч, техникийн бүлэг, техник, хэрэгсэл, нөөц сэлбэг, тоног төхөөрөмжөөр устгах бололцоогүй үед онцгой байдлын газар, бусад аж ахуйн нэгж, байгууллагаас зохих туслалцаа авч ажиллана.
- 3.2.7 Яам бусад байгууллага, ААН-ээс туслалцаа авах, удирдлага, зохион байгуулалтын ажлыг байгууллагын гамшгаас хамгаалах албаны дарга холбогдох бүлгүүдийн ахлагч нарын санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 3.2.8 Бүлгийн ахлагч нар өөрсдийн бүлгийн хүн хүч, машин техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн үед түүнийг арилгах, шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.
- 3.2.9 Гамшгаас хамгаалах орон тооны бус албаны дарга, бүлэг, хэсгийн ахлагч нар нь болзошгүй аваари саатал гарах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, бэлэн байдал зарлах үед техникийн бүлэг, хэсгүүдийг шаардлагатай үед баяр ёслол, амралт, хоногийн аль ч үед дуудаж ажиллуулна.

Дөрөв. Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, штабын дарга, чиглэл хариуцсан ажилтаны үүрэг

4.1. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын үүрэг

- 4.1.1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, мэргэжлийн байгууллагын гамшгаас хамгаалах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлнэ.
- 4.1.2. Байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулна.
- 4.1.3. Байгууллагын онцлогт зохицуулан штаб, мэргэжлийн ангийг байгуулж, гүйцэтгэх үүрэгт нь сургаж бэлтгэн, бэлэн байдлыг хангуулах, гамшигтай тэмцэх багаж хэрэгслийн дотоод нөөц бололцоог бэлтгэнэ.
- 4.1.4. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, учрах хор уршгийг арилгахад шаардагдах бараа материал, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.
- 4.1.5. Гамшгийн үед байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.
- 4.1.6. Гамшгаас хамгаалах хуульд заасан бусад шаардлагыг хэрэгжүүлнэ.
- 4.1.7. Байгууллагын бизнес төлөвлөгөөнд гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгахтай холбогдсон асуудлыг тусган хэрэгжүүлнэ.
- 4.1.8. Гамшгийн нөхцөл байдал үүсэхэд мэргэжлийн байгууллагад шуурхай мэдэгдэн, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажил зохион байгуулна.
- 4.1.9. Гамшгийн үед ЭХҮТ ТӨХХК-ийн үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим хэсгийг онцгой дэглэмд шилжүүлнэ.
- 4.1.10. ХУД-ийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллана.

Дөрөв. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын даргын үүрэг

4.2. Штабын дарга нь албаны даргад шууд захирагдан, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, дараах үүргийг гүйцэтгэнэ.

4.2.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг удирдан боловсруулж, шаардлагатай үед тодотгон, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

4.2.2. Штабын дотоод ажлыг төлөвлөн зохион байгуулах, чиглэл хариуцсан ажилтнуудын ажлыг уялдуулан зохицуулж, өдөр тутмын удирдлагаар хангана.

4.2.3. Гамшгаас хамгаалах талаар мэргэжлийн байгууллагын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

4.2.4. Гамшгийн зарлан мэдээлэл дамжуулах дотоодын системийг зохион байгуулж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулна.

4.2.5. Гамшгийн голомтод гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнээр хор уршгийг арилгуулна.

4.2.6. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.2.7. ЭХҮТ ТӨХХК-ийн байрлалд гамшгийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд гамшгийн голомтод ажиглалт, тандалт, үнэлгээ хийх, эрэн хайх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулна.

4.2.8. Гамшгийн голомтод хэв журам сахиулах, аюулгүй байдлыг хангах, эргүүл постын үйл ажиллагаанд хяналт тавина.

4.2.9. Тээврийн хэрэгслийн судалгааг гаргаж, дайчилгаагаар ажиллах тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа өгөх ажлыг зохион байгуулна.

4.2.10. Гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.3. Байгууллагын тогтвортой байдал, төлөвлөлт, бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан

Байгууллагын тогтвортой байдал, төлөвлөлт, бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан нь гамшгаас хамгаалах албаны дарга, штабын даргад захирагдан тухайн үйл ажиллагааг зохион байгуулахад дараах үүргийг гүйцэтгэнэ.

4.3.1. Гамшиг болон онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, байгууллагын хэвийн ажиллагааг хангахын тулд байгууллагын найдвартай ажиллагааны судалгаа, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

4.3.2. Аваари, саатал, үйлдвэрлэлийн осол үүссэн үед штабын удирдлага, мэргэжлийн анги бүрэлдэхүүн, гал унтраах бүлгэмтэй ажлаа уялдуулах, хамтын ажиллагааг зохион байгуулна.

4.3.3. Гамшгаас хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч сургалт, дадлага зохион байгуулах ажлыг хийнэ.

4.3.4. Орон тооны бус мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах, дадлага, сургалт хийх ажлыг зохион байгуулна.

4.4. Гамшгийн үед техник хэрэгсэл, автомашины бэлэн байдал хариуцсан ажилтан

4.4.1. Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг аврах ажилд шаардлагатай багаж, хувцас, техник хэрэгслээр хангах тооцоо хийн удирдлагад танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.4.2. Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн хангалтыг зохион байгуулна.

4.4.3. Гамшгийн уршгаар эвдэрч гэмтсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг засварлах ажлыг зохион байгуулна.

4.4.4. Тээврийн хэрэгсэл, түлшний нөөцийн тооцоог хөтлөх, хуваарилах, тэдгээрийн хадгалалт, ашиглалтын байдалд хяналт тавина.

4.4.5. Гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.4.6. Үүссэн нөхцөл байдлыг үнэлж, хангалтыг зохион байгуулах талаар саналаа боловсруулж, дээд шатны даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

4.5. Хангалт, нөөц хариуцсан ажилтан

Гамшгаас хамгаалах албаны дарга, штабын даргад захирагдан тухайн үйл ажиллагааг зохион байгуулахад дараах үүргийг гүйцэтгэнэ.

4.5.1. Гамшгийн голомтод шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бий болгоно.

4.5.2. Гамшиг болон онцгой байдлын үед шаардлагатай үед мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний байрлах сууц, хүнсний болон материалаар хангах асуудлыг судлан, гамшгаас хамгаалах штабын дарга, техник хэрэгсэл, автомашины бэлэн байдал хариуцсан ажилтантай хамтран санал боловсруулж шийдвэрлүүлнэ.

4.5.3. Гамшгийн голомтод ажиллагсдын хангалтыг зохион байгуулна.

4.5.4. Шаардлагатай бараа материалын нөөц бүрдүүлнэ.

4.6. Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан

Гамшгаас хамгаалах албаны дарга, штабын даргад захирагдан тухайн үйл ажиллагааг зохион байгуулахад дараах үүргийг гүйцэтгэнэ.

4.6.1. Холбоо мэдээлэл дамжуулах төлөвлөгөө боловсруулна.

4.6.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн зарлан мэдээллийг шуурхай дамжуулна.

4.6.3. Байгууллагын дарга болон гамшгийн голомтод ажиллагсдыг найдвартай холбоогоор хангана.

4.6.4. Дээд шатны мэргэжлийн байгууллагад гамшгийн нөхцөл байдлыг дамжуулах, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

4.6.5. Холбоо, зарлан мэдээлэл дамжуулах техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах

- 4.6.6. Орон тооны бус штаб, мэргэжлийн анги, ажилтнуудад байгууллагын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, аргачлалыг боловсруулан танилцуулж, дадлага сургууль хийнэ.

4.7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, сургалт хариуцсан ажилтан

- 4.7.1. Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулна.
- 4.7.2. Гамшгаас хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч сургалт, дадлага зохион байгуулах ажлыг хийнэ.
- 4.7.3. Орон тооны бус мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах, дадлага, сургууль хийх ажлыг зохион байгуулна.
- 4.7.4. Гамшгаас хамгаалах мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.
- 4.7.5. Дээд шатны мэргэжлийн байгууллагад гамшгийн нөхцөл байдлыг дамжуулах, мэдээлэл солилцоно.

4.8. Гамшгаас хамгаалах асуудал болон удирдлагын байр хариуцсан ажилтан

- 4.8.1. Гамшгийн үед хамгаалалт, жижүүрлэлтийг нэн даруй зохион байгуулж, компанийн нутаг дэвсгэрт хэв журам сахиулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ.

4.9. Штабын архив, сурталчилгаа, мэдээлэл, бичиг хэрэг хариуцсан ажилтан

- 4.9.1. Онцгой байдал үүссэн цагийн байдал, түүний өөрчлөлтийн талаарх мэдээ, мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу боловсруулж, холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтантай хамтран дамжуулах үүргийг гүйцэтгэнэ.
- 4.9.2. Тухайн байдлын мэдээ цуглуулах, цагийн байдлыг үнэлэхэд туслах, штабын удирдлагын тушаал шийдвэрийн дагуу гүйцэтгэгчийн биелэлтэд хяналт тавина.

Тав. Мэргэжлийн анги, бүрэлдэхүүний үүрэг

- 5.1. Мэргэжлийн анги бүрэлдэхүүн нь өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу хүн хүч, багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн байнгын бэлэн байдлыг хангана.
- 5.2. Болзошгүй аваар саатал, гамшгийн хор хөнөөлийг устгах ажилд дээд байгууллагын шийдвэрийн дагуу гамшгаас хамгаалах штабын даргын удирдлагын дор хөдөө орон нутагт гамшгийн цэгт очиж ажиллах
- 5.3. Аваари саатал гарсан үед гамшгаас хамгаалах албанаас мэдээлэл дамжуулж гишүүдийг дуудсан үед яаралтай ирж нэгдсэн зохион байгуулалтад орох
- 5.4. Бүлгийн ахлагч, гишүүд нь ажлын өдрүүд, гэрийн болон хариуцлагатай жижүүрээр ажиллах боломжгүй болсон, ар гэрийн гачигдал гарсан үед

4-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэн гамшгаас хамгаалах албаны даргаас чөлөө авч оронд нь ажиллах хүнийг томилуулна.

Зургаа. Хэсгийн ахлагч нарын үүрэг

6.1 Дотоод хяналтын хэсгийн ахлагч

- 6.1.1 Монгол Улсын Гамшгаас хамгаалах хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон компанийн дотоод журам, гамшгаас хамгаалах орон тооны бус албаны даргын гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах үүрэгтэй.
- 6.1.2 Бүлгийн гишүүд, ажилтнуудыг сургалт, дадлагад хамруулах ажилд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар бүлгийн ахлагч нарт шаардлага тавих, сургалтын чанарыг сайжруулах талаар шинэ санаа, санаачлагыг нэвтрүүлэх
- 6.1.3 Бүлгүүдийн хөдөлмөр хамгааллын багаж, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, эмийн сан, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ААД-ийн шаардлагын дагуу тогтмол бүрэн хангуулах ажилд хяналт тавих
- 6.1.4 Хяналт шалгалт, техникийн дүгнэлт, акт гаргахад шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийн хуулбар гаргуулах, бүлгийн ахлагч, гишүүдээс мэдүүлэг авах
- 6.1.5 Хяналт шалгалт хийх, акт дүгнэлт гаргах, буруутай хүмүүст хариуцлага тооцох зэрэг ажлыг хөндлөнгийн нөлөөнд үл автан үнэн бодитоор тогтоох үүрэгтэй.

6.2 Материал, хангамжийн хэсгийн ахлагч:

- 6.2.1. Компанийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл бусад албан хэрэгцээний бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг олон улс болон монгол улс, компанийн хэмжээнд мөрдөж байгаа чанар стандарт, холбогдох хууль, дүрэмд заасан шаардлагын дагуу /компанийн хэрэгцээнд/ худалдан авах ажлыг зохион байгуулах үндсэн үүрэгтэй.
- 6.2.2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгагдсан аваарийн нөөц материал, сэлбэг хэрэгсэл болон бусад бараа бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, тэдгээрийн тээвэрлэлт, хадгалалтыг үйлдвэрлэгчийн тавьсан заавар, шаардлагын дагуу хийж чанар, стандартыг мөрдөж ажиллах
- 6.2.3. Бараа бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгслийг хадгалах агуулах, склад, харуул хамгаалалт, цоож түгжээ, дохиоллын найдвартай ажиллагаа, галын аюулгүй байдлын хангах
- 6.2.4. Компанид бэлэн байгаа бараа бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар дэлгэрэнгүй судалгааг хийж, өөрчлөлт орох бүрд бүртгэж байх, мэдээллийн сантай байх.
- 6.2.5. Болзошгүй аваар саатал, бэлэн байдал зарлах үед цагийн байдалд хийсэн дүгнэлт, гамшгаас хамгаалах албаны даргын шийдвэрээр аваарийн нөөц

материал, сэлбэг хэрэгслийг зөөж тээвэрлэх, гамшгийн цэг рүү явуулах ажлыг зохион байгуулах

6.3 Хоол хүнсээр хангах хэсгийн ахлагч:

- 6.3.1. Болзошгүй аваар саатал, гэмтэл устгах, онц байдал зарласан бүс нутаг, хот, дүүргийн гамшгийн цэгт ажиллаж буй техникийн бүлэг, ажилтнуудыг хоол хүнс, зөөврийн сууц, гэр майхан, өвлийн улиралд халаалт, түлшээр хангах үндсэн үүрэгтэй.
- 6.3.2. Гэмтэл, гамшгийн хор хөнөөлийг устгахаар ажиллаж буй техникийн бүлгийн гишүүдийн хоол хүнсийг эрүүл ахуйн шаарлага хангасан цайны газраас авах буюу чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хийх ажлыг зохион байгуулна.
- 6.3.3. Болзошгүй аварги саатал, онц байдлын үед гамшгаас хамгаалах албаны даргын шийдвэрээр хөдөө орон нутаг, гамшгийн цэгт очиж ажиллах
- 6.3.4. Өвлийн улиралд гамшгийн цэгт ажиллаж буй техникийн бүлгийн гишүүд, ажилтнуудын амрах байр, зөөврийн сууцыг байнгын дулаан байлгах ажлыг хариуцна.

6.4 Санхүүгийн хэсгийн ахлагч:

- 6.4.1. Болзошгүй аварги саатал, гэмтлээс урьдчилан сэргийлэх өдөр тутмын бэлэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг цаг хугацаанд нь шийдвэрлэх
- 6.4.2. Аварги саатал, гэмтлийг устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, онц нөхцөл байдал үүссэн үед шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг шуурхай шийдвэрлэх

Долоо. Гамшгаас хамгаалах албаны хүлээх хариуцлага

- 7.1. Гамшгаас хамгаалах албаны штабын бүрэлдэхүүн, бүлэг, хэсгийн ахлагч, гишүүд нь холбогдох хууль, засгийн газар, яам, хяналтын байгууллагаас гаргасан дүрэм, журам, гамшгаас хамгаалах албаны дүрмийг зөрчиж ажлын хариуцлага алдсан үед хуулийн дагуу зохих хариуцлагыг хүлээнэ.